

**“АВТО ЗАМЫН САЛБАР ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ  
92 ЖИЛ”–ИЙН ОЙН НЭРЭМЖИТ БИЕЙН ТАМИР,  
СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

*Тэмцээнд оролцох хүмүүс КОВИД 19 цар тахлаас сэргийлэх вакцинд бүрэн хамрагдсан байх ёстойг анхаарна уу.*

### **Нэг. Ерөнхий зүйл**

Энэхүү тэмцээний зорилго нь “Авто замын салбар үүсч хөгжсөний түүхт 92 жил” -ийн ойг тохиолдуулан авто замын салбарын ажилтнуудын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, шилдэг баг, тамирчдыг шалгаруулахад оршино.

### **Хоёр. Тэмцээний төрлүүд**

Тэмцээнийг дараах төрлүүдээр зохион байгуулна. Үүнд:

1. Сагсан бөмбөг (эрэгтэй баг, эмэгтэй баг)
2. Гар бөмбөг (эрэгтэй баг, эмэгтэй баг)
3. Ширээний теннис (эрэгтэй, эмэгтэй)
4. Шатар (эрэгтэй, эмэгтэй)

### **Гурав. Тэмцээн явагдах хугацаа**

Биеийн тамир, спортын тэмцээн 2022 оны 01-р сарын, 05, 06, 07-ны өдрүүдэд болно.

Тэмцээний нээлтийн үйл ажиллагаа 2022 оны 01-р сарын 06-ны 13:00 цагт “Буянт ухаа” спорт ордонд болно. Нээлт хаалтын ажиллагаанд бүх тамирчид тухайн байгууллагынхаа нэр лого бүхий жигд хувцастайгаар жагсана. Нээлтэнд байгууллагууд өөрийн компаний нэр лого бүхий 90см х 50см хэмжээтэй самбар, байгууллагын тугийг бэлдэж жагсана.

#### **1. Ширээний теннис**

Тэмцээн 2022 оны 01-р сарын 05-ны өдрийн 09:00 цагаас "Union building" /Юнион билдинг/ А-корпус 13 давхарт байрлах “Бамбар” ширээний теннисний клубт эхэлнэ.

Google map link: <https://goo.gl/maps/26mZbF1ZMxREyPwZ6>

Ширээний теннисний тэмцээн эрэгтэй, эмэгтэй гэсэн төрлүүдээр явагдана.

#### **2. Дартсын тэмцээн**

Тэмцээн 2022 оны 01-р сарын 05-ны өдрийн 09:00 цагаас Time billiard club /нарны зам дагуу шинэ тэрэг плаза/-д эхлэнэ. Google map link: <https://goo.gl/maps/3vHJDCsBiwzWbSFC8>

#### **3. Шатрын тэмцээн**

Тэмцээн 2022 оны 01-р сарын 06-ны өдрийн 10:00 цагаас “Буянт ухаа” спортын ордны хурлын танхимд эхэлнэ.

#### **4. Сагсан бөмбөг**

Тэмцээн 2022 оны 01-р сарын 06-ны өдрийн 08:30 цагаас “Буянт ухаа” спортын ордонд эхэлнэ

#### **5. Гар бөмбөг**

Тэмцээн 2022 оны 01-р сарын 06-ны өдрийн 08:30 “Буянт ухаа” спортын ордонд эхэлнэ.

#### **Тэмцээний хаалтын ажиллагаа**

2022 оны 01-р сарын 07-ны 19.00 цагт “Буянт ухаа” спортын ордонд болно.

## **Дөрөв: Тэмцээний хураамж**

1. Сагсан бөмбөгийн эрэгтэй төрөлд оролцох байгууллага 150.000 төгрөг
2. Сагсан бөмбөгийн эмэгтэй төрөлд оролцох байгууллага 150.000 төгрөг
3. Гар бөмбөгийн эрэгтэй төрөлд оролцох байгууллага 150.000 төгрөг
4. Гар бөмбөгийн эмэгтэй төрөлд оролцох байгууллага 150.000 төгрөг
5. Ширээний теннисний төрөлд оролцох нэг хүн 20.000 төгрөг
6. Шатрын төрөлд оролцох нэг хүн 20.000 төгрөг
7. Дартсын төрөлд оролцох нэг хүн 20.000 төгрөг

Баг, тамирчдын тэмцээнд оролцох хураамжийг 2021 оны 12-р сарын 27-ны 10:00 цагаас өмнө Монголын Авто Замчдын Холбооны Хаан банкин дахь 5029541678 дансанд хийх буюу бэлнээр төлсөн байх шаардлагатай.

Тэмцээнд оролцох баг, тамирчдын албан ёсны мэдүүлэг /овог, нэр, албан тушаал, хувийн дугаар заавал бичсэн/-ийг техникийн зөвлөлийн хуралдаанаас өмнө МАЗХ-нд хүргүүлсэн байна.

Тэмцээнд оролцох баг, тамирчдын албан ёсны мэдүүлэгийг 2021 оны 12-р сарын 23-ны 15:00 цагаас өмнө ирүүлсэн байх шаардлагатай.

### **Тав: Тэмцээнд оролцогчдод тавигдах шаардлага.**

Тэмцээнд оролцогч тамирчин бүр нийгмийн даатгалын шимтгэл нь даатгуулагчийн 01 төрлөөр буюу үндсэн ажилтнаар 2021 оны 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11 сарууд төлөгдсөн байх ёстой бөгөөд дараах баримт бичгийн заавал авчирна. Үүнд:

- Иргэний үнэмлэх
- ТҮЦ машинаас хурууны хээгээр авсан НДШ-ын лавлагаа

*/01 төрлөөс бусад төрөл болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр НДШ төлсөн төлөлтийг тооцохгүй/*

Багийн бүрэлдэхүүнд тэмцээнд оролцогчдод тавигдах шаардлагыг хангасан тухайн байгууллагад үндсэн ажилтнаар ажилладаг, Дээд лиг, Спрайт А лиг, 21 аймгийн үндэсний лигт тоглодог тамирчид байдаг бол эдгээр тамирчдаас талбай дээр зөвхөн 1 тоглогч гарч тоглохыг зөвшөөрнө.

Тэмцээнд оролцогч тамирчид биеийн байцаалт, ажлын үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтэр, хурууний хээгээр авсан нийгмийн даатгалын лавлагааг тэмцээний туршид биедээ авч явах бөгөөд тэмцээний зохион байгуулагчийн тавьсан шаардлагын дагуу тухай бүрд нь шалгуулах үүрэгтэй

Баг, тамирчдын мэдүүлэгт бичсэн нэр, хувийн дугаар зөрөх, компанийн үндсэн ажилтнаас өөр хүн тэмцээнд оролцуулсан, 1-с илүү мэргэжлийн тамирчин талбай дээр гарсан маргаантай асуудлыг ерөнхий шүүгч шийдвэрлэх ба тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тухайн багийг тэмцээнээс шууд хасна.

### **Зургаа. Техникийн зөвлөгөөн**

Тэмцээний техникийн зөвлөлийн хурал 2021 оны 12-р сарын 27-ны өдрийн 14.00 цагт Google map link: <https://goo.gl/maps/mZK2GH1zXBJPofxv8> /UB tower 405 тоот танхим/-д болно. Техникийн зөвлөлийн хуралдаан дээр тэмцээний нарийвчилсан дүрмийг танилцуулж тэмцээний төрлүүдийн хэсэг бүрийн тоглолтын хуваарийг сугалааны журмаар хийнэ. Тэмцээнд 2 хүртэлх байгууллага хамтарч 1 баг болон оролцож болно.

### **Долоо. Бусад**

Баг, тамирчид хувийн дугаар бүхий шаардлага хангасан тоглолтын хувцастай байна.

Тэмцээн эхлэх цагийг хатуу баримтлах бөгөөд тоглолт эхлэх цаг зарласнаас 5 минут хоцорсон тохиолдолд хожигдсоноор тооцно.

Тэмцээний явцад гарсан маргаантай асуудлыг тухай бүрд нь техникийн комисс болон ерөнхий шүүгч шийдвэрлэнэ.

“Буянт ухаа” спортын ордонд хувцас солих өрөө гаргахгүй ба нийт тамирчдад өөрийн солих хувцас, эд зүйлээ өөрөө хариуцна. Гээсэн, алдагдсан эд зүйлийг зохион байгуулах комисс болон “Буянт ухаа” спортын ордон хариуцахгүй болохыг анхааруулж байна.

## ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧДИЙН МЭДҮҮЛЭГИЙН ЗАГВАР

### КОМПАНИЙ НЭР БАГЫН СПОРТЫН ТӨРӨЛ

№	Овог	Нэр	Регистерийн дугаар	Биеийн өндөр (см)	Хувийн дугаар	Үүрэг	Спортын зэрэг	Албан тушаал
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								

МЭДҮҮЛЭГ ГАРГАСАН БАГИЙН АХЛАГЧ:

ОВОГ НЭР:

УТАСНЫ ДУГААР:

# ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧДИЙН МЭДҮҮЛЭГИЙН ЗАГВАР

## КОМПАНИЙ НЭР ГАНЦААРЧИЛСАН СПОРТЫН ТӨРӨЛ

№	Овог	Нэр	Регистерийн дугаар	Биеийн өндөр (см)	Хүйс	Спортын зэрэг	Албан тушаал
1							
2							
3							
4							
5							
6							
7							
8							
9							
10							

МЭДҮҮЛЭГ ГАРГАСАН БАГИЙН АХЛАГЧ:

ОВОГ НЭР:

УТАСНЫ ДУГААР: